

I-V ангийн зохион найруулж, дуурайн найруулж бичих чадварын агуулгын залгамж холбоо

Анги	1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
БИЧИХ ЧАДВАР					
Зохион найруулж, дуурайн найруулж бичих	1.2.в. Зураг, бүдүүвчид тохирсон 3-4 үгтэй өгүүлбэр зохиож бичих			4.2д. Үйл явдлыг өрнүүлэн, утгын уялдаа холбоотой богино өгүүлэг зохиох	5.2в. Эхийн үйл явдлын орчныг өөрчлөн богино өгүүлэг хүүрнэн зохион бичих
Зохион найруулж, дуурайн найруулж бичих	1.2.г. Багшийн хэлсэн 2-4 үгээс бүтсэн өгүүлбэрийг сонсож, цээжээр бичих	2.2.д Багшийн хэлсэн 5-6 өгүүлбэрийг сонсож, цээжээр бичих			5.2.г.Зохиолын санааг нэгтгэн дүгнэн, товчилж бичих
			3.2д. Баярласан сэтгэлээ илэрхийлж, бүтцийн дагуу талархсан утгатай захидал бичих	4.2е. Өгсөн бүтцийн дагуу утгын уялдаа холбоотой бахархсан утгатай захидал бичих	5.2.д. Бусдын үзэл бодлыг дэмжиж, эсвэл эсэргүүцсэн утгатай захидал бичих
		2.2.е. Өгсөн бүтцийн дагуу мэндчилгээ бичих	3.2е. Хүсэл мөрөөдөл, зорилготойгоо нийцүүлж төлөвлөгөө зохион бичих	4.2ж. Бусдыг сайн сайхан зүйлд уриалж бүтцийн дагуу уриалга бичих	" 5.2.е. Өөртөө тохиолдсон явдлаа сэтгэгдэл, мэдрэмжээр илэрхийлэн өдрийн тэмдэглэл бичих"
		2.2.ж. Өгсөн бүтцийн дагуу болсон явдлаа ойлгомжтой бичих	3.2ж. Өгсөн зааврын дагуу тоочин жагсааж бичих	4.2з. Өгсөн асуултын хүрээнд сонины товч мэдээ бичих	5.2.ж Чухал, шинэ үйл явдлыг баримтаар нотлон, бүтцийн дагуу мэдээ бичих
		2.2.з. Өгсөн бүтэц зааврын дагуу баярлаж талархсанаа илэрхийлсэн талархал бичих		4.2.и. Хүндэтгэлийн үг хэрэглэн, бүтцийн дагуу урилга бичих	5.2з. Бусдын анхаарлыг таттал яггаж бичих
	1.2.д. Өгсөн загвар, асуулт, цуврал зургийн дагуу 3-4 өгүүлбэр зохиож бичих	2.2.и. Сэдэвт болон цуврал зургийг хараад утгын холбоотой 4-5 өгүүлбэр бүхий эх зохиох	3.2з. Өгсөн сэдэв, бүтцийн дагуу үлгэр зохиож бичих	4.2к. Бүтцийн дагуу үлгэр зохиохдоо баатрын гадаад дүр байдлыг дүрслэн бичих	5.2.и Жүжигт баатруудын харилцан яриаг нэмэн бичих
		2.2.к"Ертөнцийн гурав"-ын хэлбэрийг дуурайн зохиож бичих	3.2и. Шүлэг, "ертөнцийн гурав"-ын хэлбэрийг дуурайн зохиож бичих	4.2л. Шүлгийн хэлбэрийг дуурайж зохион бичих	5.2.к Адил төстэй шинжийг харьцуулан утгыг далдлан оньсого зохион бичих
	1.2.е. Өөрийгөө 4-5 өгүүлбэрээр танилцуулж бичих	2.2.л.Зааврын дагуу гэр бүлээ танилцуулж бичих	3.2к.Өгсөн бүтцийн дагуу уншсан номоо тэмдэглэн бичих	4.1м. Уншсан номыг танилцуулж бичихдээ сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэх	5.2.л.Баримт, зураг, график хэрэглэн баталгаа, нотолгоотой санаагаа илэрхийлж бичих "
		3.2л. Уншсан зохиолын талаар сэтгэгдлээ илэрхийлэн бичих		5.2м. Өгсөн бүтцийн дагуу үлгэр зохиох	



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Эхийн орчин нь тухайн үйл явдал **хаана**, **хэзээ** болж байгааг илэрхийлдэг. Орчин нь үйл явдал болж буй **орон байр**, **улирал**, **цаг хугацаа**, **цаг агаарын байдал** зэргээс бүрддэг.

орон байр

- хотод
- далайд
- ууланд

Цаг хугацаа

- зун, хавар, намар, өвөл
- өглөө, өдөр, орой, шөнө

Цаг агаар

- бороотой
- шуургатай
- нартай
- салхитай

1 Зураг болон өгүүлбэрүүдийн ажиглаж хараад, орчин хэрхэн өөрчлөгдөж байгаа дүрслэн зохион бичээрэй.



Жихүүн салхитай, цас бударсан хүйтэн өдөр байсан ч Саран, Анар хоёр чаргаар ээлжлэн гулгаад их л хөгжилтэй байлаа.



Дөнгөж соёолсон шинэхэн ногооны үнэр ханхалж, шувуудын жиргээн сонсогдсон нэгэн сайхан өдөр Саран, Анар хоёр байгальдаа өнгө нэмж мод тарилаа.







Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



Эхийн орчин нь тухайн үйл явдал **хаана, хэзээ** болж байгааг илэрхийлдэг. Орчин нь үйл явдал болж буй **орон байр, улирал, цаг хугацаа, цаг агаарын байдал** зэргээс бүрддэг.

1 “Уралдаан” өгүүллэгийн сонгосон хэсгийн орчныг өөрчлөн бичээрэй.

УРАЛДААН



Наадам ойртсон өдрүүдийн галт наран бадарна. Өнгийн цэцэгс намуухан салхины аясаар үл мэдэг найгах нь үзэсгэлэн төгөлдөр харагдана. Орхоны гол толины тусгал мэт гялалзан ойном. Их үд өнгөрч, үсэргээний цаг болоод байв. Аав ээжид “Хүүгээ үсэргээнд явуулнаа, одоо тав хүрчихлээ” гэх дуулдав. Би энэ үгийг сонсоод хөөрөн баясав. Одоо би “гуяа алгадан гүйхгүй, хонинд унадаг хээр морио ташуурдан цогиулахгүй боллоо шүү дээ” гэж бодсоор гэрээс чавхдан гарвал дээд айлын хүүхдүүд айсуу.

2 Өгүүллэгийн орчны юуг өөрчлөхөө сонгож будаарай.

Орон байр

- хотод
- далайд
- ууланд


Цаг хугацаа

- зун, хавар, намар, өвөл
- Өглөө, өдөр, орой, шөнө

Цаг агаар:

- бороотой
- цастай
- шороон шуургатай

3 Хэрхэн өөрчлөхөө төлөвлөн зураглал хийнэ.



4 Орчныг дүрслэн бичихийн тулд ямар үгс хэрэглээ төлөвлөн бичнэ.

Үйл явдал	Орчин	Яаж мэдрэгдсэн бэ?
Харагдсан зүйл	тал газар,	цэлгэр цагаан тал,
Сонсогдсон зүйл	морьдын үүрсэх,цасны шаржигнах чимээ
Мэдрэгдсэн зүйл

Эхийн орчныг өөрчлөн богино өгүүллэг зохион бичье



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр.....цаг



Эхийн орчин нь тухайн үйл явдал **хаана**, **хэзээ** болж байгааг илэрхийлдэг. Орчин нь үйл явдал болж буй **орон байр**, **улирал**, **цаг хугацаа**, **цаг агаарын байдал** зэргээс бүрддэг.

орон байр

- хотод
- далайд
- ууланд

Цаг хугацаа

- зун, хавар, намар, өвөл
- өглөө, өдөр, орой, шөнө

Цаг агаар

- бороотой
- шуургатай
- нартай
- салхитай

5 Төлөвлөсний дагуу эхийн орчныг өөрчлөн бичнэ.

6 Бичсэн эхээ шалгуурын дагуу дахин сайжруулан дэвтэртээ бичээрэй.

Өөртөө тавих асуулт	тийм	үгүй
Өгүүллэгийн орчны юуг өөрчлөхөө сонгосон уу?		
Хэрхэн өөрчлөхөө төлөвлөн зураглал хийсэн үү?		
Хэрэглэх үгсээ оновчтой тодорхойлж чадсан уу?		
Цаг агаарыг тодорхой дүрсэлсэн үү?		
Нүдэнд харагдаж, чихэнд сонсогдохуйц дүрсэлж чадсан уу?		

Дууссан:онсарөдөр цаг

Өөрийн үнэлгээ: (5) (6)



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Эхийг уншиж, утга санааг ойлгосны дараа гол санааг өөрчлөхгүй үгийн тоог багасгаж бичихийг товчлон бичих гэнэ. Өөрөөр хэлбэл хэрэг явдлыг цөөн үгээр илэрхийлж ярьж бичнэ.

1 Дараах өгүүлбэрүүд дэх тодруулсан үгсийг ашиглан өгүүлбэрийг хурааж бичээрэй.

Гол нэр үг, зайлшгүй шаардлагатай үйл үгийг сонгоно.

хэн? юу?
Нэгэн хүү дүүрэн тостой торх гэртээ хүргэхээр өнхрүүлж явжээ. яасан?

....Гэрийн хойморт зургаан настай хөөрхөн бор охин хурганы хуучин уут, нэмнээ нөхөж сууна.

2 Зурагт эхийн хэсэг тус бүрийг хураангуйлж бичээрэй.



Хүүд өглөөний сэрүүнд дугуй унамаар санагдаж гэнэ. Дугуйны гинж нь сайн болохгүй байсан тул тэр уруу газрыг сонгов.



Хүүд дугуйгаа унах маш таатай байлаа. Гэнэт дугуйны гинж мултарч хүү хүчтэй унав. Түүний хамар нь ихэд өвдөж, цус гарав.



Хамар, хөлийн өвдөг нь маш их өвдөж байсан тул хүү чангаар уйллаа. Ээж нь хүүгийнхээ уйлахыг сонсоод яаран ирлээ.



Ээж нь шархыг нь цэвэрлэж, наалт нааж өгөөд “Гинжийг нь янзалсан хойно унаарай” гэж хэлсэн шүү дээ гэв.



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг

- 1 Эхээс гол үг, гол өгүүлбэрийг ялган санааг алдагдуулахгүй товчлон бичээрэй.

Уншихдаа:

- Эхийг ойлгон уншаарай.
- Түлхүүр үгийн доогуур зураарай.
- Гол санааг агуулсан өгүүлбэрийг ялган бичээрэй.

Түлхүүр үг:
Эхэд олон давтагдсан
нэр үг, зайлшгүй
хэрэгтэй үйл үг



СОНИУЧ ОХИН

Охин нэг тахиатай юм санж. Тахиа үүрээр донгодов. Бяцхан эзэн минь сайн байна уу? гэж буй мэт дууддаг ажээ. Тэгснээ охины дэргэд очиж гараас нь будаа идэж зэрэгцэн зогсдог байв. Нэг өдөр охин айлынхаа эм тахиаг ихэд сонирхож тахиагаа түүгээр солив. Дараа өдөр найз охиных нь нугас гоё санагдаж тахиагаа нугасаар солив. Гөлөг хөтөлсөн хүнтэй тааралдав. Нугасаа гөлгөөр солив. Гэртээ ирээд олон дахин солио хийснээ ярихыг нь гөлөг сонсоод, "Ийм эзэнтэй байх дургүй. Ийм хүн нөхрөө хүндэтгэж чадахгүй" гэж бодов.




- 2 Зурсан үг, өгүүлбэрээ оруулан эхийг товчлон бичээрэй.

Дэмжсэн, эсэргүүцсэн утгатай захидал бичье

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг



- Учир шалтгааныг илэрхийлсэн материал цуглуулах
- Дурдсан нотолгоо баталгаатай байх



Лантуун дохио ТББ-аас 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр албан ёсны мэдэгдэл гаргаж, УИХ-ын 76 гишүүн тус бүрт албан бичиг хүргүүллээ. Манай байгууллага цар тахлын үед морь уралдуулах нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж харж байна. Энэ бол санаатай хүүхдийн эрхэд халдсан үйлдэл, амь нас эрүүл мэндэд заналхийлж байна. Морин уралдаанаа зогсоохыг үүгээр мэдэгдэж байгааг хүлээн авна уу.

Бусад иргэний нийгмийн байгууллагууд болон иргэдийг тус санаачлагыг дэмжин өөрсдийн байр сууриа илэрхийлж бодитоор оролцохыг уриалж байна гэжээ.

- 1 Цар тахлын үед морь уралдуулах нь чиний хувьд зөв үү, буруу юу? Тоочин бичээрэй.


Яагаад буруу гэж....	Яагаад зөв гэж....
өвчлөл нэмэгдсэн.....	100 жилийн ой.....
.....
.....
.....
.....

2 Нотолгоо-1

3 Нотолгоо-2

Улсын хэмжээнд 2021.06.29-ний байдлаар коронавируст халдвараар өвчилсөн 0-18 насны 25038 хүүхэд байгаа нь нийт 112694 тохиолдлын 22,3%-ийг эзэлж байна. Насны бүлгээр авч үзвэл 0-4 насны 5690, 5-9 насны 8000, 10-14 насны 7597, 15-17 насны 3571 хүүхэд тус тус халдварлажээ. Тиймээс дэмжиж байна.

Улс хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан морин уралдаанд оролцохоор уяачид, унаач хүүхэд, морьдоо бэлтгэн ирсэн билээ. Халдвар хамгааллын дэглэмээ баримтлан оролцох тул уриалгыг дэмжихгүй байна.



4 Уриалгыг дэмжсэн захидал ноороглон бичье.

Халдварт өвчин бол аюултай

Сайн байцгаана уу.

Лантуун дохио ТББ-аас гаргасан цар тахлын үед морь уралдуулах нь заналхийлж байна гэсэн уриалгыг дэмжиж байна. УИХ-ын гишүүн бүр..... гаргах нь чухал. Яагаад гэвэл морин уралдаанд 9000 гаруй морь уралдах тоо гарсан байна. Энэ нь ийм тооны морь унана гэсэн үг. Үүнээс ч олон тооны.....бас оролцоно. Тиймээс халдвар авах..... билээ. Одоо ч халдвар авсан хүүхдийн тоо байна. Энэхүү УИХ гишүүд, бусад ТББ, иргэд, уяачидгэдэгт..... байна.

Та бүхэнд ажлын амжилт хүсье. 5-р ангийн сурагч О.Энхтөр

6 УИХ-ын гишүүд яагаад энэ асуудлыг хэлэлцэх болов?

.....

7 Нотолгоо-1 нь уралдааныг зөвшөөрөх баримт болж чадах уу?

.....

8 Нотолгоо-2 нь уралдааныг зөвшөөрөх баримт болж чадах уу?

.....

5 Уриалгыг эсэргүүцсэн захидал ноороглон бичье.

Үндэсний баяр наадам

Сайн байцгаана уу.

Лантуун дохио ТББ-аас гаргасан уриалгыг дэмжихгүй байна. Учир нь энэ жил тохиож байна. Үндэсний баяр наадмын бол монгол морины хурд, гайхамшгийг харуулсан уралдаан билээ. Унаач уячид бүтэн жил бэлтгэж, уралдуулдаг. Цар тахал гарсан хэдий ч бид зөвлөмжийн дагуу хүн хоорондын барин, ариутган,тогтмол зүүж биелүүлж байна. Тиймээс УИХ гишүүд та бүхэн зохион байгуулахыг зөвшөөрнө үү.

Та бүхэнд ажлын амжилт хүсье. 5-р ангийн сурагч Н.Төгс




Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг




Өдрийн тэмдэглэлд юу бичих вэ?

- ✓ Уулзсан хүмүүсийн тохиол, учрал
- ✓ Гэр орон сургууль дээр болсон үйл явдал
- ✓ Өдөр тутмын үйл явдал
- ✓ Сонин хачин үйл явдал
- ✓ Баяр хөөр уйтгар гунигтай зүйл
- ✓ Төрсөн сэтгэгдэл
- ✓ Үзэл бодол, дүгнэлт



Зоригтын “Өдрийн тэмдэглэл хөтөлж, өөрийн түүхээ бүтээе” дэвтэртэй танилцъя.

2021 оны 10 сарын 20 өдөр Баасан гараг



Тогтмол хийх үйл

- Өглөө эрт боссон
- Дасгалаа хийсэн
- Хичээлээсээ хоцроогүй
- Анги цэвэрлэгээ хийх
- Гэрийн ажилд туслах
- Ном унших
- Найзтайгаа тоглох

Хамгийн сонирхолтой

Өнөөдөр манай анги сургуулиас зарласан “Бидний ая дуу” урлагийн үзлэгийн шалгаруулалтад оролцсон өдөр. Би хамтлаг бүжиг, найрал дуу, уран уншлагын гээд 3 төрөлд оролцохоор бэлтгэсэн. Хамтлаг бүжиг дуусаад, тайзны ард гарч амьсгаагаа гүнзгий авах тэр мөчид Номин надад гоё бүжиглэлээ, баярлалаа гэж хэлсэн. Үнэхээр үүлэн дээр хөвж байгаа юм шиг сэтгэл сайхан болсон доо. Ингээд шалгаруулалт дуусч, нийлбэр оноогоороо манай анги “Шилдэг анги”, би өөрөө уран уншлагаараа тэргүүлэв. Хамгийн их **хөдөлмөрлөсөн** хамтын хүч, багшийн минь хичээл зүтгэл их байлаа. Гэртээ ирээд ядарснаа мэдэв.

Хийхийг хүсэж байгаа зүйл

- Зурагтаар танилцуулга нь гарсан “Оюун ухааны музей” үзэх
- Өдрийн тэмдэглэлээрээ ном бүтээх

Хийгээгүй үйл, яагаад?

Энэ 7 хоногт урлагийн үзлэгт бэлтгээд гэрийн ажилд туслаагүй юм байна. Ээж минь их ядарсан байх даа.

- Заавар:**
- Хийсэн бол ногоон
 - Дутуу хийсэн бол шар
 - Хийгээгүй бол будахгүй
- Цагаа агаарыг дугуйгаар тэмдэглэнэ.



1 Зоригтын өдрийн тэмдэглэлтэй танилцсанаа дүгнэе. Өнгөөр ялгасан нүдэнд дүгнэн бичээрэй.

Дэвтрийн бүтэц	Өнгөрсөн цагт	Одоо цагт
Өдрийн тэмдэглэлийн нэр		
Он, сар, өдөр	
Цаг агаарын тэмдэглэгээ	Тухайн өдөртөө зохицон хувцаслах, байгалийн ухааны хичээлийн ажиглалт хийдэг.	Тухайн өдөртөө зохицон хувцасладаг.
Тогтмол хийх үйл	
Хамгийн сонирхолтой	Хамгийн дурсамжтай зүйлээ тэмдэглэдэг. Зоригтын сэтгэл хөдлөл илэрч байна.	
Хийхийг хүсч байгаа		
Хийгээгүй үйл, яагаад?		
Заавар	Өөрт ойлгомжтой хөтлөхийг эрмэлздэг.	Ойлгомжтой, цэгцтэй байхад анхаардаг.

2 Чи өдрийн тэмдэглэл хөтөлдөг үү?

- Тийм
- Үгүй

Хэрэв **тийм** бол ямар загвараар хөтөлдөг вэ? Танилцуулна уу?

Хэрэв **үгүй** бол ямар загвараар хөтлөх вэ? Зураглаж үзүүлээрэй.

3

..... миний “.....” өдрийн тэмдэглэлийн загвар



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг



Мэдээнд орох баримт мэдээлэл **үнэн бодитой, шинэлэг** байх ёстой.

Мэдээ → эхлэл → хэн? юу? хэзээ? хаана? яасан?
 → гол → дэлгэрүүлсэн хэсэг
 → төгсгөл → мэдээ бичсэн хүний нэр, он, сар, өдөр

Баримт мэдээлийн эх сурвалжуудаа давхар тэмдэглэнэ.

1 Бичих мэдээгээ төлөвлөө.

Эхлэл хэсэг	Маш том хэмжээний мөндөр орсон тухай
Гол хэсэг	Байрны цонх хагарч хохирол учирсан тухай
Төгсгөл хэсэг	Мэдээг бичсэн хүний нэр


2 Мэдээгээ ноороглон бичье.

Маш том хэмжээний мөндөр оржээ

Говьсүмбэр аймагт 2021 оны 07 сарын 02-ны өдөр маш том хэмжээний мөндөр оржээ. Энэ нь теннисний бөмбөгтэй дүйцэхүйц юм. Хүчтэй, том мөндөр орж байшингийн 67 цонх, 10-аад автомашины шил хагарчээ.

NTV мэдээний албаны сурвалжлагч Г.Дулам

3 Баримтыг судлан, мэдээгээ дэлгэрүүлж бичээрэй.



4 Баримтыг үндэслэн, мэдээгээ дэлгэрүүлж бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....





Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Мэдээнд орох баримт мэдээлэл **үнэн бодитой, шинэлэг** байх ёстой. Баримт мэдээлийн эх сурвалжуудаа давхар тэмдэглэнэ.

1 Бичих мэдээгээ төлөвлөө. Бүтцийг гүйцээн бичээрэй.

Эхлэл хэсэг	
Гол хэсэг	Намрын спартакиадаар олон үйл ажиллагаа зохиосон тухай
Төгсгөл хэсэг	

2 Баримттай танилцаарай.

баасан, бямба гарагт

8 ангийн 95 сурагч



зураг

БАРИМТ

120 дугаар сургуулийн
5а ангийн сурагч
Б.Норжмаа

Сургуулийн аварга
анги

3 Мэдээгээ ноороглон бичсэн нь. Бүтцийн дагуу бичсэн байна уу?

Манай анги аварга боллоо

Намрын спартакиад нь 9 дүгээр сарын 2 дахь долоо хоногт боллоо. Бага ангийн сурагчдын дунд буухиа, 200м, 400м-ийн гүйлт, байрнаас уртад харайх гэсэн төрлөөр явагдсан. Манай анги буухиа, 400м, байрнаас уртад харайх гэсэн төрөлд амжилттай оролцсон. Манай ангийн сурагч У.Цэлмэг 400м-ийн гүйлтийн аварга болсон.

4 Баримтыг үндэслэн сайжруулан бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Бусдын анхаарлыг татахуйц ятгаж бичье



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг



Бусдын анхаарлыг татаж ятгах нь ямар нэг юмны талаар хүмүүсийн ой ухаанд удаан хугацаагаар хадгалагдан үлдэх мэдээлэл болдог.

Мэдээллийн эх

- ✓ Бичвэр их
- ✓ Мэдээлсэн
- ✓ Танин мэдэхүй

Сэдэв ижил

Зар сурталчилгааны эх

- ✓ Бичвэр бага
- ✓ Ятгасан
- ✓ Хэрэглээ

Ятгаж бичихдээ:

- 1.Нэрээ оновчтой сонгоно.
- 2.Гол үгээ ялгана.
- 3.Гол шинж чанар юу вэ?
4. Бусдыг ятгана.
5. Товч тодорхой бичнэ.

1 Анхаарал татаж ятгах зорилгыг харуулсан зургуудыг ажиглаарай.




Нэхмэл үйлдвэрлэлийн салбар жилд 1.5 их наяд тонн ус хэрэглэдэг. Үйлдвэрт ашигладаг усны 90-95% нь бохир ус болдог.

а



Эвдэрхий цоргоо засъя-Эх дэлхийгээ аваръя

б



в

2 Дээрх зургууд хүмүүсийг юунд ятгасныг асуултаар ярилцан, таамаглан бичээрэй.

	Асуулт	Таамаглая
а	Яагаад нэхмэлийн үйлдвэрийн зургийг бохир усны хоолойтой хамт тавьсан байна вэ?	Нэхмэлийн үйлдвэр гэдэг бидний хувцсыг үйлдвэрлэдэг газар. Их наяд=1 000 000 000 000 1.5 их наяд=
б	“Эвдэрхий цоргоо засъя-Эх дэлхийгээ аваръя” гэж уриалсан юм бол?	
в	Та нарын гараар барьдаг бүх зүйл толботой байна юу?	

Дууссан:онсарөдөр цаг

Өөрийн үнэлгээ:

1 2



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Бусдын анхаарлыг татаж ятгах нь ямар нэг юмны талаар хүмүүсийн ой ухаанд удаан хугацаагаар хадгалагдан үлдэх мэдээлэл болдог. **Бичих төлөвлөгөө:**

- ✓ Гол санаа
- ✓ Агуулга
- ✓ Дүрс зураг хэрэглэх

1

Мэдээллийн эхийг уншаад, гол үгээ ялгаж тэмдэглээрэй..

Нэхмэлийн үйлдвэр усыг бохирдуулдаг

Нэхмэлийн салбар нь дэлхийн хамгийн том ус бохирдуулагчдын жагсаалтад хоёрдугаарт ордог. Орчин үед загварыг нэг удаагийн хэрэглээ болгосон нь даавууны үйлдвэрлэлийг 50%-аар нэмэгдүүлсэн байна. Хүн амын өсөлт, загварын брэндүүд нь нэхмэл бүтээгдэхүүний эрэлтийг улам нэмэгдүүлсэн. Өндөр хөгжилтэй орнуудын дундаж гэр бүл жил бүр дор хаяж 30 кг хувцас хаядаг. Хаягдсан нэхмэл эдлэлийн дөнгөж 15% -ийг хандивлаж эсвэл дахин боловсруулдаг.

"100 хувь байгалийн даавуу" гэсэн шошготой хувцас нь жиндээ 25% химийн бодис агуулдаг. Нэг тонн нэхмэл эдлэл үйлдвэрлэхэд нэг тонн орчим химийн бодис зарцуулагддаг. Нэхмэл үйлдвэрлэлийн салбар жилд 1.5 их наяд тонн ус хэрэглэдэг. Будах, шингээх үйл явц нь цэвэр усыг их хэмжээгээр хэрэглэдэг Тухайлбал: дунджаар нэг тонн будагдсан даавуу 200 тонн ус хэрэглэдэг байна. Үйлдвэрт ашигладаг усны 90-95% нь бохир ус болдог.

2

“Шинэвтэр хувцсаа дахин ашиглая” уриатай ятгасан эх зохиох төлөвлөгөө

Зорилго нь	Гоё харагдсан бүхнийг худалдан авахгүй байх
Хэрэглэгдэх үгс
Гол санаа	Усыг бохирдохоос бага ч гэсэн сэргийлье.
Агуулга Хүн бүр шинэвтэр хувцсаа өөрчлөн өөр зүйл хийж дахин ашиглах
Дүрс зураг хэрэглэх	   



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг

Бичих төлөвлөгөө:



- ✓ Зорилго
- ✓ Хэрэглэгдэх үгс

- ✓ Гол санаа
- ✓ Агуулга
- ✓ Дүрс зураг хэрэглэх

4

“Шинэвтэр хувцсаа дахин ашиглая” уриатай ятгасан эх зохион бичье.

Шинэвтэр хувцсаа дахин ашиглая



.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

5

Төлөвлөгөө зохиож, ятгасан эх зохиож бичиж хавсаргаарай.

Зорилго нь
Хэрэглэгдэх үгс
Гол санаа
Агуулга
Дүрс зураг хэрэглэх

Эвдэрхий цоргоо
засъя-Эх дэлхийгээ
аварья

6

НЯН БАКТЕРИ
ТАНЫ ЭРГЭН ТОЙРОНД ҮРГЭЛЖ БАЙДАГ

Гараа мөгтмөл
угааж эрүүл амьдарцгаая.

В



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг




Онъсого зохиоходоо:

- ✓ Онъсоголох зүйлээ сонгоно.
- ✓ Гадаад, дотоод шинж чанарыг жагсаан бичнэ.
- ✓ Бусдаас ялгарах онцлог шинжийг сонгоно.
- ✓ Онцлог шинжийг өөр төстэй шинжтэй зүйлээр орлуулна.
- ✓ Шүлэглэж зохионо.

Гаалгах онъсогоын утга нь далд байна.

Тэр юу вэ ?

1 Онъсого зохиоходоо дарааллын дагуу адил төстэй шинжийг харьцуулна гэдгийг санаарай.

Зохио дараалал	Алхмууд	
Онъсоголох зүйлээ сонгоё.	<p>Үнэгийг сонголоо. Үнэгий тухай бидний мэддэг онъсого</p> <ul style="list-style-type: none"> ✓ Нам нам гүйдэлтэй ✓ Сайхан хүүхэн ✓ Навчин шэр дээлтэй ✓ Сам шүүргүй 	
Гадаад ба дотоод шинжийг жагсаан бичье.	<p>Өнгө зүс, бие- улбар шар, гэдэс цагаан, хөл.....</p> <p>.....</p> <p>Амьдрах орчин</p> <p>Хоол тэжээл.....</p> <p>Хөдөлгөөн, чадвар.....</p> <p>.....</p>	
Онцлог шинжийг ялгая.	<ul style="list-style-type: none"> ✓ Улбар шар зүстэй ✓ өргөн үүрлэх танхимтай гүн нүх ✓ Арга заль мэхтэй ✓ нарийхан гарцтай, ✓ Ухаалаг амьтан ✓ жалга, толгодын энгэрт 	
Өөр төстэй зүйлтэй харьцуулъя.	<ul style="list-style-type: none"> ✓ өргөн үүрлэх танхимтай гүн нүх-өргөн зам ✓ нарийхан гарцтай замын цагаан гарц ✓ Арга заль мэх-аюулаас аврагч 	
Шүлэглэж зохиоё.	<ul style="list-style-type: none"> Уулын энгэрээр гүйдэлтэй ✓ Өргөн замын гүнд Үзэсгэлэнт шар гүнж ✓ Өөгүй цагаан гарц (Тэр юу вэ?) ✓ Арга заль мэхээрээ ✓ Аюулаас хурдан мултрагч (Тэр юу вэ?) 	

2 Үнэгий онцлог шинжүүдийг ашиглан миний зохиосон онъсого. Таагаарай.

Ж.....энгэрээр я.....
 Ж.....шар
 (Тэр юу вэ?)

.....

 (Тэр юу вэ?)




Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Онъсого зохиохдоо:

- ✓ Онъсоголох зүйлээ сонгоно.
- ✓ Гадаад, дотоод шинж чанарыг жагсаан бичнэ.
- ✓ Бусдаас ялгарах онцлог шинжийг сонгоно.
- ✓ Онцлог шинжийг өөр төстэй шинжтэй зүйлээр орлуулна.
- ✓ Шүлэглэж зохионо.



Тэр юу вэ ?

1 сонгон оюуны зураглалын аргаар судалъя.




2 тухай миний зохиосон онъсого



3 сонгон оюуны зураглалын аргаар судалъя.

4 тухай миний зохиосон онъсого



Дууссан: он сар өдөр цаг

Өөрийн үн 1 2 3 4



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг

1 Доорх баримтуудыг ашиглан усаа хайрлах тухай эх зохион найруулж бичээрэй. Мөн ном сурах бичиг, интернет, бусад эх сурвалжаас баримт цуглуулан нэмж болно.

Цэвэр усны хомсдолтой холбоотой баримтууд

- а. Манай оронд 2019 оны байдлаар 12591 гол горхи, булаг шанд, 3895 нуур тойром, 512 рашаан байдаг гэсэн судалгаа байна.
- б. 2007 оны усны тооллогын судалгаагаар 683 гол горхи, 1484 булаг шанд, 760 нуур тойром ширгэж үгүй болсон. 2020 оны усны тооллогын судалгаагаар 116 гол горхи, 381 булаг шанд, 180 нуур тойром, 5 рашаан ширгэж үгүй болсон байна.
- в. Дэлхийн хэмжээнд нэг хүний хоногт хэрэглэх усны дундаж хэрэглээ 100-105 л байдаг байна. Гэтэл манай улсын орон сууцанд амьдардаг нэг хүний хоногийн усны дундаж хэрэглээ 230-280 литр байна. Харин гэр хорооллын хэрэглэгчид дэлхийн дундаж түвшнээс 5-10 дахин бага буюу 6-8 литр ус хэрэглэж байна.
- г. Уур амьсгалын дулаарал, уул уурхайн олборлолт, ойн хомсдол зэргээс шалтгаалан жил бүр маш олон тооны газрын гадарга дахь усны эх үүсвэр ширгэж үгүй болж байна. Эдгээр шалтгаанууд бүгд хүний буруутай үйл ажиллагааны улмаас үүдэлтэй юм.
- д. Ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны доголдол, уул уурхай, арьс шир, ноос, ноолуурын үйлдвэрүүдийн цэвэршүүлээгүй хаягдал усны нөлөөгөөр усны нөөц бохирдож, хомсдох эрсдэл өндөр байна.

2 Дээрх тоон баримтуудыг дараах хүснэгтүүдэд оруулж, бичлэгтээ мөн ашиглаарай.

Хүснэгт 1: Ширгэж үгүй болсон усны эх үүсвэрийн тоо

	гол горхи	булаг шанд	нуур тойром	рашаан
2007 он	-
2020 он

Хүснэгт 2: Нэг хүний хоногт хэрэглэх усны дундаж хэрэглээ

	дэлхийн хөгжингүй орнуудын оршин суугчид	УБ хот дахь орон сууцны оршин суугчид	гэр хорооллын оршин суугчид
нэг хүний хоногт хэрэглэх усны дундаж хэрэглээ

3 Илтгэлээ усаа хайрлан хамгаалах, хэрэглэсэн усыг өөр зорилгоор дахин ашиглах, гол мөрөн булаг шандаа бохирдуулахгүй байх, мод тарих зэрэг ач холбогдол бүхий уриалга өгүүлбэрээр төгсгөөрэй.



Баримт мэдээлэл нь **үнэн бодитой, шинэлэг, харьцуулсан** байх

эхлэл хэсэгт: Хэзээ хаана ямар асуудал үүссэн

гол хэсэгт: Учир шалтгаан, нөхцөл байдал,

төгсгөл хэсэгт: Асуудлыг хэн хэрхэн шийдвэрлэж болох, яавал зохих

Area with horizontal dotted lines for writing.



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөрцаг



Бодит амьдрал дээр байдаггүй, бидний хараагүй, сонсоогүй зүйлийг амьдрал дээр байдаггүй зүйл гэдэг. Үлгэрээс бодит байдал ба уран сэтгэмжийг ялгаж сурна.

Үлгэрээ зохиохдоо:

- ✓ Үлгэрийн сэдвээ сонгох
- ✓ Үйл явдлыг төсөөлөх
- ✓ Зохиох үлгэрт орох үгээ цуглуулах

Уран сэтгэмжээр
төсөөлөн гол
дүрээ сонгон үлгэр
зохиогоорой.

1 Үлгэр зохиох сэдвээ сонгоё.

- | | | | |
|---|---|--|---|
| <input type="checkbox"/> Найз нөхөрлөлийн тухай | <input type="checkbox"/> Эрэлхэг зоригтой баатрын тухай | <input type="checkbox"/> Залхуу хойрог хэний тухай | <input type="checkbox"/> Эцэг эхийн ачлалын тухай |
|---|---|--|---|

2 Сонгосон нэг сэдвээ үйл явдлыг төсөөлье.

.....


.....

3 Үйл явдлын эхлэл, гол, төгсгөл хэсэгт ямар ямар үг хэрэглэх вэ? Өөрийн зохиох үлгэрийн үгүүдээ сонгоорой.

- | | | |
|--|--|--|
| <p>Эхлэл хэсэгт</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Эрт <input type="checkbox"/> Эрт урьд <input type="checkbox"/> Эхлээд <input type="checkbox"/> Анх <input type="checkbox"/> Тээр жил | <p>Гол хэсэгт</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Дараа нь <input type="checkbox"/> Тэгээд <input type="checkbox"/> Мөн <input type="checkbox"/> Түүнчлэн <input type="checkbox"/> Харин | <p>Төгсгөл хэсэгт</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Эцэст нь <input type="checkbox"/> Ингээд <input type="checkbox"/> Сүүлд нь <input type="checkbox"/> Төгсгөлд нь <input type="checkbox"/> Ингэж |
|--|--|--|

4 Үлгэрийн төлөвлөгөө зохиоё.


Сонгосон үгээ ашиглан товч бичээрэй.





Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр
.....цаг

 Бодит амьдрал дээр байдаггүй, бидний хараагүй, сонсоогүй зүйлийг амьдрал дээр байдаггүй зүйл гэдэг. Үлгэрээс бодит байдал ба уран сэтгэмжийг ялгаж сурна.

5 Ноороглон бичээрэй.

Large rounded rectangular area with horizontal dotted lines for writing.

6 Бичсэнээ үлгэрээ гэрийнхэндээ уншиж өгөөд дахин юуг сайжруулахаа бичээрэй.

Two horizontal dotted lines for writing.

Дууссан:онсарөдөрцаг

Өөрийн үнэлгээ: (5) (6)